



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/96.

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийн дагуу Арвайхээр хотын 1, 9 дүгээр багийн авто замыг улсын чанартай А0302 дугаар авто замтай холбох ажлыг 1,009,489,550 (нэг тэрбум есөн сая дөрвөн зуун наян есөн мянга таван зуун тавь) төгрөгөөр Өндөрсант хайрхан ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3.Шалгарсан аж ахуйн нэгжид гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0148

D:My Doc. Zahiramj. Zasag darga